

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2023 оны 06 сарын 16 өдөр

№ R-2023-32

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт заасны дагуу ХасБанк ХХК ("ХасБанк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2023 оны 06 дугаар сарын 9-ний өдрөөс 16-ны өдрийн хооронд хуралдсан цахим санал хураалтын хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг үндэслэн:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. ХасБанкны холбогдох этгээд болох [redacted] ("Зээлдэгч") нь эргэлтийн хөрөнгийн зориулалтаар, дараах үндсэн нөхцөл бүхий зээлийн шугамын гэрээ ("Зээлийн шугам")-г байгуулахаар ХасБанктай харилцан тохиролцсоныг:

Нийт дүн:

7,000,000,000 төгрөг

Хугацаа:

12 сар

Хүү:

Төгрөгийн зээлийн шугам жилийн

Зээлийн ангилал:

Зээлийн нөхцөл:

[redacted]
Зээлийн хүсэлтийн эхний
нүүрэнд тусгагдсаны дагуу

2. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭУХ") ТУЗ-ийн хуралтай нэгэн зэрэг болсон цахим санал хураалтын хурлаараа хэлэлцээд Зээлийн шугамыг батлах саналыг ТУЗ-д хүргүүлснийг;
3. Зээлийн шугам нь Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1.2 дахь заалтад заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл болохыг;
4. Банкны тухай хуулийн 17.9 дэх хэсэгт Банкнаас холбогдох этгээдтэй хийх хэлцэл нь банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй байж болохгүй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд холбогдох хуульд заасан шаардлага, журмыг баримтална гэж заасан. Зээлийн шугам, түүгийг батлах үйл ажиллагаа нь энэхүү шаардлагыг хангасан болохыг; болон
5. ТУЗ нь Зээлийн шугамыг ЭУХ-ны санал болгосны дагуу батлах хүсэлтэй байгааг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

1. Зээлийн шугамын гэрээг үүгээр баталсугай.
2. Зээлдэгчийн нийт үүргийн хэмжээг 19,400,000,000 төгрөгөөс хэтрүүлэхгүйгээр Зээлийн шугамын дагуу зээл хүсэлт шийдвэрлэж олгох эрхийг ХасБанкны Зээлийн удирдлагын хороо ("ЗУХ")-нд олгосугай.
3. Зээлийн шугамын гэрээний хугацаанд Зээлдэгчийн хүсэлтээр банкнаас өгөх бүх төрлийн зөвшөөрөл олгох, шаардлагатай тохиолдолд Зээлийн шугамын гэрээний дагуу олгогдсон зээлийн нөхцөл өөрчлөх асуудлыг ХасБанкны ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлэх эрх олгосугай.
4. Энэхүү Тогтоол гарсан өдрөөс хойш хүчин төгөлдөр болох бөгөөд шийдвэр гарсан өдрөөс хойш 12 сарын хугацаанд хүчинтэй байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХҮҮЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.МӨНХЦЭЛМЭГ